

СПОРТЫН НИЙТЛЭЛ, НЭВТРҮҮЛЭГТ АЖИГЛАГДАЖ БУЙ
ЗАРИМ АЛДАА МАДГИЙН ТУХАЙД

Ч. Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (PhD), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: спортын сэтгүүл зүй, хөтлөгчийн ур чадвар, үг сонголтын алдаа, учир зүйн алдаа, техникийн алдаа, сэдэв сонголт, баримтын алдаа.

Спортын нийтлэл, нэвтрүүлэг манай ОНМХ-д өөрийн зохих байраа эзлээд удаж байна. Телевизийн суваг бүр өөрийн гэсэн спортын хөтөлбөртэй, өдөр тутмын хэвлэлүүд ч талбайнхаа тодорхой хэсгийг энэ сэдэвт зориулж буй юм. Спортын сэтгүүлч мэргэшлээр БТДС боловсон хүчин бэлтгэж байна. Гэвч манайд спортын сэтгүүл зүй төдийлөн хөгжөөгүй, энэ чиглэлээр мэргэшсэн хэвлэл мэдээллийн ажилтан хангалтгүй байгаа нь нууц биш юм. Иймээс ч мэргэжлийн шаардлага хангахгүй нийтлэл, нэвтрүүлэг ХМХ-үүдэд түгээмэл үзэгдэж, спортын зарим сэтгүүлч, хөтлөгчийн ур чадварын тал дээр ч анхаарах зүйл багагүй байна.

Эдгээр алдаа мадгийг хэд хэдэн хэсэгт ерөнхийлөн ангилж болохоор байна.

Спортын нийтлэл, нэвтрүүлэгт түгээмэл үзэгддэг алдааны нэг бол **үг сонголтоос** шалтгаалан гардаг мадаг юм. Улмаар уншигч, үзэгчдэд буруу

ташаа ойлголт төрүүлэх нь элбэг билээ. Жишээ үзье.

«УЕФА-гийн цомын шөвгийн наймын хоёр дахь хариу тоглолтууд энэ долоо хоногт болж өнгөрлөө» гэсэн өгүүлбэрт¹ хоёр дахь гэсэн үг илүүдсэнээр сонсогчдод ташаа ойлголт өгөхүйц болжээ. Аваргуудын лигийн болон УЕФА-гийн цомын тэмцээний нэг үе нь хоёр тоглолтоос бүрддэг бөгөөд өрсөлдөгч багууд өөрийн болон эсрэг багийн талбай дээр тус бүр нэг удаа тоглодог. Тиймээс хариу тоглолт боллоо гэж хэлэх нь зөв юм. Хоёр дахь хариу тоглолт гэснээс болж хариу тоглолт хоёр удаа болдог, эхний тоглолттойгоо нийлээд гурван ч удаа тогложихдог мэт ойлголт төрж байна.

Дээрхтэй ижил жишээ. МҮТВ-ийн «Спорт» хөтөлбөрөөр² Францын хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний явцыг мэдээлэхдээ тайлбарлагч *«"Марсель" багийн тоглогч Кана тоглолтын 2-р үеийн 79 дэх минутад "Пари Сен-Жермен"-ий хаалганд цорын ганц бөмбөгийг орууллаа»* гэсэн юм. Мөн л үг илүүдсэнээр (2-р үеийн) тоглолтын үе бүр наад зах нь 79 минут, цаашлаад үүнээс ч илүү үргэлжилдэг юм шиг болжээ. Нэг тоглолт тус бүр нь

45 минут үргэлжлэх 2 үеэс бүрддэг. Тийм учир эсвэл тоглолтын 79 дэх минутад, эсвэл 2-р үеийн 34 дэх минутад гэх нь зөв юм.

Монгол хэлний зарим үгийн цаад нарийн утгыг тайлбарлагчид маань мөн л мэдрэх хэрэгтэй. Өшиглөсөн бол хөлөөрөө, мөргөсөн бол толгойгоороо гэж ойлгогдох нь зүйн хэрэг. Тэгсээр байтал толгойгоороо мөргөж гоол орууллаа, хөлөөрөө өшиглөж өрсөлдөгчийнхөө хаалганд бөмбөг хийлээ гэж спортын мэдээллийн хөтөлбөрүүдээр ярьж байгаа нь найруулгын ноцтой алдаа юм. Угаасаа хөлөөрөө мөргөнө, толгойгоороо өшиглөнө гэж байхгүй учир илүүц тодотгол оруулах нь шаардлагагүй билээ.

3:1-гийн (4:1-гийн) харьцаатай хошуучилж эхэллээ гэж манай зарим телесэтгүүлч ярьдаг. Утгыг нь нягтлаад үзвэл 2:1-гийн (3:1-гийн) харьцаатай байхад хошуучлаагүй, гагцхүү 3:1 (4:1) болж байж л дөнгөж сая хошуучилж эхэлсэн мэт болжээ. Эдгээр жишээнд эхэллээ гэдэг үг хамаг будлианы эзэн болж байна. Зүй нь хошуучилж байна гэх билээ.

«"Реал Мадрид"-ын Фигу, "Милан"-ы Кака нар оновчтой дамжуулалтыг сайн өгдөг байна», «Коку үнэхээр өндөр ур чадвартай гоолыг орууллаа»³ гэж тайлбарлагч ярьж байна. Дамжуулалт оновчтой юм бол сайн, муу байна гэж байхгүй. Тиймээс сайн гэдэг тодотгол илүүц юм. Мөн гоол өндөр ур чадвартай байж болохгүй. Магадгүй, тайлбарлагч гайхамшигтай, ер бусын гэж хэлэх гэсэн байж болно.

«Өмнөд Америк-ийн хэсэгт хамгийн сонирхолтой тоглолт энэ бүсийг [ДАШТ-2006-гийн Өмнөд Аме-

рикийн бүсийн урьдчилан шалгаруулах тоглолтууд] тэргүүлж байгаа хоёр улс болох Бразил-Аргентиний хооронд боллоо. Талбайдаа болсон энэ тоглолтод аргентинчууд довтлогч Э.Креспогийн дублийн ачаар өрсөлдөгчөө 3:1 харьцаагаар хожсоноор /.../ ДАШТ-д оролцох эрхээ өвөртөллөө»⁴. Үг буруу сонгосноос мөн л ташаа ойлголт бий болж байна. Буруу үг сонгосныгоо буруу ерөнхийлөн хамаатуулснаас тоглолт нь өөрийн гэсэн талбайтай байдаг мэтээр эл өгүүлбэрийг ойлгож болох нь. Зүй нь нутагт нь болсон тоглолтод аргентинчууд гэх юм.

Үг нуруших бол зөвхөн теле хөтөлбөрүүдэд төдийгүй, тогтмол хэвлэлд ч баттай хадагджээ. «Тэр тоглолт Молдавытай тоглосон тоглолт байлаа» гээд бичиж байх юм. Өгүүлбэрийн 6 үгийн 3 нь тоглох гэсэн язгууртай байгаа нь төвөггүй анзаарагдана. Түүнчлэн «Тоглолтын тооны харьцаа 1:0-гийн харьцаатай үргэлжилж байна»⁵ гэх мэтээр ярих нь элбэг болжээ. Тоглолт үргэлжлэхээс тооны харьцаа үргэлжилдэггүйг бодолцох хэрэгтэй.

Баг хэдийгээр 11 тоглогчоос бүрддэг ч энэ үг ганц тоон дээр хэрэглэгддэг. Нэг жишээг сонирхъя. «Италийн "Парма" баг UEFA-гийн хагас шигшээд Оросын "ЦСКА" багтай таарсан билээ. Тэд энэ тоглолтдоо багийнхаа үндсэн шигшээг бус залуучуудаа тоглуулах бололтой. Учир нь яг энэ тоглолтод ойролцоохон хугацаанд дотоодынх нь аварга шалгаруулах тэмцээний чухал тулаанууд болох тул ийм шийдвэр гаргаж байгаа гэнэ»⁶ гэсэн нь алдаа мадагтай юм (баг-тэд).

Зарим оновчгүй нэр байнга давтагдсаны улмаас «алдаа мадаггүй» мэт болжээ. Үүний тод жишээ бол Мадридын «Реал»-ыг эзэн хааны клуб гэж нэрийддэг явдал юм⁷. Энд хоёр зүйлийг бодолцох хэрэгтэй. 1-рт, Испани үндсэн хуульт хаант засаглалтай орон бөгөөд эзэн хаангүй, гагцхүү вантай. 2-рт, реал гэдэг үгийн уг язгуур нь ройал буюу ван, вангийн гэсэн үгээс гаралтай.

Телесэтгүүлчид цэнхэр дэлгэцээр илүү үг хэлчих гээд байдаг нэг том дутагдалтай. Үг болгоны цаана утга байдаг гэдгийг телесэтгүүлчид маань бодолцож, өгүүлбэрүүдээ найруулж баймаар. «Одод-studio» нэвтрүүлгийн «Алтан дагина» булангаар 1990 оны хөл бөмбөгийн ДАШТ-ний шөвгийн дөрвийн Англи-Германы тоглолтын хэсгийг үзүүлсэн юм⁸. Үндсэн ба нэмэлт цаг 1:1-ийн харьцаатай өндөрлөсөн тул торгуулийн цохилтоор тоглолтын хувь заяаг шийдэх болов. 2:1-гийн харьцаатай байхад Л.Маттеус гоол оруулж 2:2 болсон юм. Үүнийг «Германы ахлагч Лотар Маттеусын цохилт хүчтэй болж, тооны харьцааг мөн л 2:2 болголоо» гэж тайлбарласан нь ташаа болжээ. Мөн гэдэг үг давтагдах санааг илэрхийлэх бөгөөд урьд нь тооны харьцаа 2:2 байсан мэт ойлголт өгч байна.

Спортын нийтлэл, нэвтрүүлэгт учир зүйн буюу логикийн алдаа

түгээмэл үзэгддэг. Энэ төрлийн алдаа үүсэхэд үг буруу сонгох, үг дутаах зэрэг шалтгаан нөлөөлж байна. Заримдаа манай сэтгүүлчид жаахан чамирхах гээд алдаа мадаг гаргачихдаг. 2005 оны Конфедерацийн цомын хагас шигшээ тоглолтод Аргентин, Мексикийн шигшээ учирч, үндсэн ба нэмэлт үе 1:1-гийн харьцаатай дуусч, торгуулийн цохилтоор ялагчаа тодруулсан юм. Энэ тухай

«
*Монгол хэлний зарим үгийн
утгыг тайлбарлагчид маань
мэдрэх хэрэгтэй. Өшиглөсөн бол
хөлөөрөө, мөргөсөн бол
толгойгоороо гэж ойлгогдох нь
зүйн хэрэг. Тэгсээр байтал
толгойгоороо мөргөж гоол
орууллаа, хөлөөрөө өшиглөж
өрсөлдөгчийнхөө хаалганд
бөмбөг хийлээ гэж спортын
мэдээллийн хөтөлбөрүүдээр
ярьж байгаа нь найруулгын
ноцтой алдаа юм.*

»

«Ингээд үндсэн таван хөл бөмбөгч бүгд гоол хийсэн тул дахиж нэг нэг тоглогч цохилт хийх болсон. Энэ үед Мексикийн Риккардо Осориогийн цохисон бөмбөгийг Аргентины хаалгач Люкс хааж чадсан ба харин Камбьяс-согойн цохьсон бөмбөг торны цаана “унаж” чадлаа»⁹ гэж бичжээ.

Цохижээ гэдэг үгийг хоёр өөрөөр бичсэнээс гадна нэг л багийн таван хөл бөмбөгч гоол оруулсан мэт ойлгогдохоор болжээ. Гэхдээ хамгийн гол нь бөмбөг торны цаана унана гэдгийг утгачлан хөөвөл бөмбөг хаалгыг давж газардсан, улмаар гоол ороогүй болж таарах нь. Тиймээс торонд орсон гэх нь зөв юм.

Иймэрхүү учир зүйн алдаанд үг буруу сонгохоос гадна үг дутааснаар хүрч байна. Тухайлбал: Серби ба Черногорийн довтлогч Матея Кежманыг «өнгөрсөн улиралд “Челси” багийн бүрэлдэхүүнд багтаж чадаагүй»¹⁰ гэж

бичжээ. Багийн бүрэлдэхүүнд багтаагүй гэдгийг тухайн багийн гишүүн болоогүй гэж ойлговол зохино. Энд сэтгүүлч үндсэн бүрэлдэхүүнд гэж тодотгох нь зөв байжээ. Ингэж тодотгосноор М.Кежман «Челси» багийн гишүүн мөн, гагцхүү ногоон талбай дээр тэр бүр гардаггүй байжээ гэж ойлгогдоно.

Хөлбөмбөгийн тоглолтын явцыг мэдээлэхдээ гоол орсныг оноо авлаа гэж тайлбарлах нь манай телевизүүдийн спортын мэдээллийн хөтөлбөрт түгээмэл үзэгддэг алдаа болжээ. Гоол орох, оноо авах нь тэс өөр зүйл билээ. Нэг гоол оруулсныг багтаа нэг оноо авчирлаа гэдэг. Оноог тоглолтын эцсийн дүнгээр тогтоодог юм. Хэдэн гоолын зөрүүтэйгээр хожсоноос үл хамааран хожсон бол гурван оноо, тэнцсэн бол хоёр баг тус тус нэг оноо авдаг. Харин хожигдсон баг оноогүй хоцордог. Гурван гоол оруулсан ч өөрийн хаалганд дөрвөн бөмбөг оруулаад хожигдсон бол манай тайлбарлагчид гурван оноо авчихлаа мэтээр ярьдаг нь дэндүү буруу юм. Тэгвэл 10:0 харьцаатай хожчихвол 10 оноо авчихлаа мэтээр ярих гээд байдаг. Тиймээс гоол, оноо хоёрын хоорондох ялгааг тайлбарлагчид маань өөрсдөө эхлээд зөв ойлгох хэрэгтэй.

Үг сонголтоос гадна **техникийн шинжтэй** алдаа спортын сэдэвтэй нийтлэлүүдэд бат хадагджээ. Тухайлбал: тэмцээний оноог тогтмол хэвлэлд буруу өгдөг нь зуршил болоод байна. Жишээлбэл: Мадридын «Реал» 4 гоол, «Барселон» 2 гоол оруулсан байлаа гэж бодъё. Тэгвэл «Барселон» «Реал»-д 4:2-ын харьцаатай хожигдлоо гэж ярьдаг, бичдэг. Зүй нь хэрэв хожигдлоо гэж ярих юм бол бага тоо нь урдаа

ордог, харин хожлоо гэж ярьвал том тоо нь өмнөө орох ёстой юм. Тодруулбал «Барселон» «Реал»-д 2:4-ын харьцаатай хожигдлоо гэж бичих нь зөв билээ.

Хэвлэлээс авсан жишээг үзье. «"Рома" багийн ахлагч Тотти баг нь "Сиена"-д 2:0-ээр хожигдож байх үед эсрэг багийн тоглогч Франческо Колоннезег үг хэлээр дайрч доромжилсны учир таван тоглолтод оролцох эрхээ хасуулжээ»¹¹. Зүй нь 0:2-оор хожигдож байх үед гэх юм.

Зарим хүнд энэ нь ач холбогдолгүй зүйл мэт санагдаж болно. Тийм ээ, жирийн уншигчдад энэ нь ач холбогдолгүй байж болно. Тэгвэл спортын сэтгүүлч энэ асуудлыг үл тоомсорлож эс болох бөгөөд номтой юмыг ном ёсных нь дагуу бичих нь мэргэжлийг нь эзэмшээд, дипломыг нь өвөртөлсөн хүний үүрэг билээ.

Олимпийн тоглолтын үеэр медаль авсан орны жагсаалтыг гаргахдаа манай сэтгүүлчид авсан медалийн тоог нэмж, нийлбэрээр нь байрлуулчихдаг. Тухайлбал: ОХУ 2 алт, 3 мөнгө, 6 хүрэл медаль авсан, АНУ-ын шигшээ 3 алт, 2 мөнгө, 4 хүрэл авсан бол ОХУ-ыг 11 медальтайгаар 1-р байранд жагсааж, АНУ-ыг 9 медальтайгаар удаах байр эзлүүлдэг. Гэтэл олон улсын жишгээр байр эзлүүлэхэд юуны түрүүнд алтан медалийн тоог харгалздаг. Энэ нь ч аргагүй юм. Олимпийн аваргын алдар хүнд ийн үнэлэгддэг билээ. Тиймээс медалийн нийт тоогоор дутуу ч АНУ нэгдүгээр байранд жагсах ёстой. Үүний нэг адил цорын ганц алтан медаль авсан орон 10 мөнгө, 20 хүрэл, нийт 30 медаль авсан улсаас дээгүүр жагсах ёстой юм.

Хэл найруулгын алдаанаас гадна манай спортын сэтгүүлчид мэдээний **сэдвийн сонголтыг** оновчтой болгомоор санагддаг. Орос «ах»-аа хэтэрхий бараадсан нь анзаарагдахгүй өнгөрөхийн аргагүй. «ЦСКА тийм багтай оноолт таарлаа» (2005 онд УЕФА-гийн цомыг авахаас өмнөх үеийн жишээ), «Дэлхийн аваргын урьдчилан шалгаруулах тэмцээний хүрээнд Оросын шигшээ Эстонийн шигшээ багтай тоглолоо» зэрэг лидтэй мэдээ спортын хөтөлбөрийн хамгийн эхэнд гардаг бөгөөд зарим тохиолдолд үүгээр хязгаарлагдах нь бий. Хэдэн жилийн өмнө спортын мэдээллийн нэгэн хөтөлбөрөөр Хөлбөмбөгийн ертөнцөд олны анхаарлыг татсан үйл явдал боллоо. Оросын Владикавказын «Алани» баг дасгалжуулагчаа солилоо гэсэн агуулгатай мэдээ явсныг миний бие санаж байна. Дэлхийн шилдэг клуб, шигшээгийн жагсаалтад Оросын баг, ЦСКА, «Алани» хэддүгээрт жагссаныг анхааралдаа авмаар. Ер нь «Алани» гэж баг тэртээ 10-аад жилийн өмнө Оросын аваргаар шалгарсныг байтугай, ийм баг байдгийг Монголын хэр олон спортын хорхойтон мэдэх бол?.. Олон нийт Европын их тав хэмээгддэг Итали, Испани, Англи, Герман, Францын шигшээ, мөн «Ливерпуль», «Манчестер Юнайтед», Мадридын «Реал», «Барселон», «Ювентус», «Милан», «Бавари» зэрэг багийн тухай мэдээллийг илүүтэй шимтэн сонирхдог. Энэ нь ч аргагүй юм. Хөлбөмбөгийн ертөнцөд чухамхүү эдгээр шигшээ, багууд л сүүлийн үеийн «загвар»-ыг дэглэдэг.

Өөр жишээ татъя. ТВ-9 телевизийн 2005 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн «Тоймчийн хөтөлбөр»-ийн

спортын мэдээ 2006 оны хөлбөмбөгийн ДАШТ-ий урьдчилан шалгаруулах тоглолтоос эхэлсэн нь зүй ёсны юм. Гэвч дахиад л Оросын шигшээгээс мэдээ эхэлнэ. Ямар ч сонирхолгүй Орос-Люксембургийн тоглолтыг нэн дэлгэрэнгүй, тодорхой мэдээлж, дараа нь Словаки-Оросын тоглолтод шилжинэ. Хайнцлаар өндөрлөсөн энэ тоглолтын дараа Словакийн шигшээ «оноогоор илүү болсон» гэж ташаа мэдээлээд (үнэн хэрэгтээ эдгээр багийн оноо тэнцэж, бөмбөгийн зөрүүгээр Словаки Португалийн араас 2-рт жагссаныг хөлбөмбөг сонирхогч бүр мэднэ) бусад хэсгийн тоглолтын тухай өгүүлэх гэсэн боловч цагтаа баригдаж 2-3-хан үг хэлээд спортын мэдээ төгсөв.

Гадаад нэрсийг англиар «**галиглаж**» дууддаг нь бараг хэвийн үзэгдэл болох шахаад байна. Үүнд хамгийн ихээр гар бие оролцсон сэтгүүлч бол Ч.Тамир юм. Тэрээр Нидерландын Seedorf-ыг Зеедорф гэхийн оронд Сидорф, Германы Klose-г Клозе гэхийн оронд Клоуз, Францын Henry-г Анри гэхийн оронд Хэнри зэргээр «галигладаг» нь хэл мэддэгийн илрэл үү, аль эсвэл эсрэгээр, харин хэл мэддэггүйн илрэл үү? Үндэстэн бүрийн ярьдаг хэлийг бүгдийг нь англиар галигчлаж болно гэж үү? Тэгвэл Тамир гэдэг нэрийг англиар галиглаж дуудвал (Тэмие, Тэмөө) хүн таних бол уу? Ч.Тамир заримдаа ташаа мэдээлэл дамжуулах нь ч бий. Тухайлбал, «Одод-studio» нэвтрүүлгийнхээ «Алтан дагина» булангаар (2005.06.19) хөлбөмбөгийн ДАШТ-ий түүхээс танилцуулахдаа 1990 оны тэмцээний шөвгийн наймын тоглолтод Камеруны хаалганд хийсэн Колумбийн

цорын ганц гоолыг К.Вальдеррама орууллаа гэсэн нь үнэнд нийцэхгүй юм. 2:1-тай өндөрлөсөн тэр тоглолтод Камеруны хоёр гоолыг Р.Милла, Колумбийн гоолыг Ф.Ринкон нар оруулсан билээ.

Спортын телесэтгүүлчдэд түгээмэл өөр нэг дутагдал бол нэрсийг «галиглах»-аас гадна **хазгай мурий унших** явдал юм. Манай зарим нэвтрүүлэгч, хөтлөгч тамирчдын нэрсийг ойлгохын аргагүй болтол «зажилж», монголчилж хэлж байна. Заримдаа хэн гээд хэлчихэв гээд бодогдохоор. ТВ-9 телевизийн 2005 оны 9-р сарын 16-ны өдрийн «Энэ өдөр» мэдээллийн хөтөлбөрийн төгсгөлд нэвтэрсэн спортын үйл явдлын тоймын нэвтрүүлэгч Шараповаг Шарпова, «Вильярреал»-ыг «Вальяраал», Рональдог Орнаалдо, Берхкампыг Бэркоомп гэж сонсохын аргагүй болтол нь дуудаж байв. Мөн Нидерландын Ключвертыг Килверт, Аргентины Камбьяссог Ломбьясо гэх мэтээр аргагүй л монгол зангаар хялбарчилж уншина. Энэ бол энгийн нэгэн жишээ. Ер нь нэвтрүүлэгчид гадаад нэрсийг эфирт гарахынхаа өмнө хэдэн удаа дуудаад зүгшрүүлчихэд нэг их цаг үрэхгүй юмсан.

Тайлбарлагчийн **ур чадвартай** холбогдуулж нэг зүйл хэлмээр байна. Хөлбөмбөгийн тэмцээн 90 минут үргэлжилдэг. Энэ урт хугацаанд нэг тоглогчийн нэр хэд хэдэн удаа дурдагдаж болно. Тэгвэл тайлбарлагч боломжтой үед нь (шуурхай довтолгооны үеэр өөр зүйл ярих боломжгүй нь ойлгомжтой) тухайн тоглогчийн талаар сонирхолтой баримт хэлж байх хэрэгтэй. Энэ бол тийм ч амар ажил биш. Харин тоглолтын

хэсгээс үзүүлж байгаа бол нэг тоглогчийн талаарх мэдээллээ нуршаад байлгүйгээр ярьчихаж болох юм. Гэтэл тэмцээний явцыг тайлбарлахдаа сэтгүүлчид маань нэг хөл бөмбөгчийн тухай нэг л янзын мэдээлэл дамжуулдаг дутагдал ажиглагдаж байна. Тухайлбал: Мадридын «Реал» Хятадын багуудтай хийсэн аялан тоглолтыг тайлбарлахдаа Л.Фигугийн нэр дурдагдах болгонд л Фигу аялан тоглолт дууссаны дараа Миланы «Интер» багт тоглоно гэж нуршиж байлаа. Мөн Фигу Мадридын «Реал»-д 45 мянган доллараар шилжсэн гэж саяыг *мянга* болгож ташаарсан удаатай¹².

Ер нь саяыг мянга болгочих гээд байдаг дутагдал манай телесэтгүүлчдэд байна. «Odod studio»-гийн «Спорт» нэвтрүүлгийн нэгэн дугаарт¹³ Английн хөлбөмбөгчин Дэвид Бекхэмийн намтрыг өгүүлэхдээ сэтгүүлч түүнийг Мадридын «Реал»-д 34 мянган еврогоор шилжсэн нь үнэтэй хөлбөмбөгчдийн жагсаалтын 11 дэх үзүүлэлт болсон гэж ярьсан юм. Хөл бөмбөг мэддэггүй хүнд саяыг мянга гээд ярьчих нь буруу ойлголт өгөх аюултай. Жилд 6,4 сая евроны цалинтай, ганцхан Peps-i-ний рекламнаас 5 сая евро олдог одыг 34 мянган евроны үнэтэй гэсэн нь доромжилсон ч юм шиг... Мөн Бекхэмийг «дээрээ нэг эгчтэй, доороо нэг дүүтэй» гэж танилцуулсан нь учир зүйн алдаатай болсон билээ. Дээрээ дүүтэй, доороо эгчтэй гэж байх боломжгүй шүү дээ.

Баримтын алдаа түгээмэл үзэгдэж байна. Энэ нь сэтгүүлчийн мэдлэгтэй шууд холбоотой. Өдөр тутмын зарим хэвлэлд спортын анхан шатны мэдлэггүй сэтгүүлчид ажиллаж байгаа нь тоогүй. «Зууны мэдээ»

сонины 2005 оны 6 дугаар сарын 18-ны дугаарт «"Интер" Италийн аварга болов» мэдээ нийтлэгджээ. Мэдээний лндэд «Италийн хөлбөмбөгийн цомын аваргаар "Интер" тодорлоо. Эхний тоглолтод тэд өрсөлдөгч "Рома"-г 2:0-ээр хожсон юм. Хариу тоглолтод бас л хожлоо» гэх аж. Цомын эзэн болох, аварга болох нь тэс өөр ойлголт бөгөөд монголчилбол Цагаан сарын барилдаанд түрүүлсэн бөхийг Наадмаар түрүүлж, улсын аварга боллоо гэсэнтэй агаар нэг билээ.

Түүнчлэн мөн дугаарт «Мексикүүд Японы багийг хожлоо» мэдээ «Тивүүдийн шилдэг баг оролцсон Холбооны цомын тэмцээн Германд үргэлжилж байна» гэж эхэлж байх юм. Конфедерацийн цомын тэмцээнд тивүүдийн шилдэг баг бус, харин тивүүдийн аваргууд оролцдог. Тивийн аваргаар гагцхүү тивийн шилдэг баг л тодорно гэж хэн нэгэн хэлж болно. Тэгвэл Европын аварга Грек Европын шилдэг баг мөн үү? Хэрэв мөн бол ДАШТ-2006-д «Б» хэсэгтээ долоон багаас яагаад Украин, Турк, Данийн араас дөнгөж 4-р байранд жагсав?

Мөн дугаарт нийтлэгдсэн «Б.Хатанбаатар, Б.Анхчимэг нар тэргүүлсээр» мэдээнд «11 өргийн дараахь байдлаар эмэгтэйчүүдээс олон улсын мастер Б.Анхчимэг 10 хожлоор тэргүүлж байна» гэжээ. Тэмцээний

явцыг хүснэгтээс сонирхоход ОУМ Б.Анхчимэг 9 хожиж, 2 хайнцаж, нийт 10 оноо авсан байна. Тиймээс 10 хожлоор гэх бус, харин 10 оноотой гэх нь зөв юм. Тэгэхээр хожил, онооны ялгааг мэддэггүй сэтгүүлч манай ХМХ-үүдэд түгээмэл бололтой гэж дүгнэж болох нь.

Спортын нийтлэлүүдэд үг үсэг, тооны алдаа тун элбэг тохиолдож байна. Эдгээр «жижиг» алдаагүйгээр спортын нийтлэлийг төсөөлөх аргагүй болжээ. 2006 оны Конфедерацийн цомын шувтаргын тоглолтод Бразилийн шигшээ Аргентиний багийг 4:2 харьцаатай хожсон гэж ташаа (зүй нь 4:1) мэдээлсэн байх жишээтэй¹⁴. Алтан медалийн төлөө аливаа тоглолт бол онцгой үйл явдал болохыг сэтгүүлчид

маань мартах эрхгүй.

Баримтын илэрхий алдаанууд ч мэр сэр үзэгдэж байна. Жованни Трапаттони «Ювентус» багийг 1983 онд Аваргуудын лигийн аварга болгож байсан гэжээ¹⁵. Гэтэл 1993 оноос хойш л тус тэмцээн Аваргуудын лиг нэртэй болсон бөгөөд үүнээс өмнө Аваргуудын цом нэртэй байсан билээ.

Баримтын алдаатай өөр нэг жишээ үзье. «Одод олноороо буйр сэлгэв»¹⁶ мэдээнд «Сери А-д эргэн ирсэн "Фиорентина" клуб солилцоо наймаанд идэвхтэй оролцож ... авьяаслаг тоглогчдыг багтаа авчээ»

гэсэн байх юм. Гэтэл «Фиорентина» Сери А-д 2004 онд эргэж ирсэн билээ. Үүнийг спортын сэтгүүлч байтугай хөлбөмбөг сонирхдог хэн ч мэднэ. Иймэрхүү жижиг сажиг баримтыг нет рүү ороод шалгачихад уул нь ердөө минутын л ажил билээ.

«ӨС»-ийн 2005 оны 8 дугаар сарын 27-ны дугаарт «С.Жеррард Европын шилдэг хөлбөмбөгчнөөр шалгарлаа» гарчигтай мэдээ нийтлэгджээ. Уул нь тив, дэлхийн шилдэг хөлбөмбөгчнийг оны эцэст шалгаруулдаг журамтай. С.Жеррард 2004-2005 оны Аваргуудын лигийн тэмцээний шилдэг тоглогчоор шалгарсныг сэтгүүлч ийн «андуурчээ».

Спортын сэтгүүлчид маань зарим тохиолдолд өөрсдөө буруу ташаа ойлголттой явдаг нь харамсалтай. 2005 оны 10 дугаар сарын 10-нд UBS телевизээр нэвтэрсэн спортын нэвтрүүлгийн дараа надтай тааралдсан танилууд маань «2006 оны ДАШТ-нд Европын хэсгүүдээс 1, 2-р байр эзэлсэн багууд оролцохгүй биз дээ? Тамир ингэж яриад байх юм» гэж байсан. Уул нь 8 хэсэгт хуваагдсан Европоос хэсэгтээ 1-р байр эзэлсэн 8 баг шууд, 2-р байр эзэлсэн багуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй 2, 2-р байр эзэлсэн үлдсэн 6 баг хоорондоо тоглож, хоёр тоглолтын дүнгээр ялсан 3 баг, үүн дээр тэмцээнийг зохион байгуулагч Герман нэмэгдээд нийт 14 баг ДАШТ-нд оролцох эрхтэй болох юм.

Спортын үйл явдлыг мэдээлэхдээ сэтгүүлч хамгийн чухал баримтыг «мартчихаж» байгаа нь таагүй. «Дэлхийн дээд амжилтыг шинээр тогтоов»¹⁷ мэдээнд Финляндад болж буй дэлхийн хөнгөн атлетикийн аварга

шалгаруулах тэмцээнд тулгууртай харайлтын Оросын тамирчин Ирина Исинбаева өмнө нь өөрийнхөө тогтоосон амжилтаа ахиулан, дэлхийн дээд амжилтыг шинээр тогтоосон тухай өгүүлнэ. Гэвч ямар амжилтыг яаж ахиулсан талаар нэг ч тоо баримт алга. Энэ нь хамгийн олон хүүхэдтэй эхийн тухай өгүүлэхдээ хэдэн хүүхэд төрүүлсэн тухай нь дурдалгүй өнгөрөхтэй адил юм. Уул нь Исинбаева 5 м 1 см-ийн өндрийг давсан нь эмэгтэй хүн анх удаа 5 метрээс өндөр харайсан тохиолдол байжээ.

«ӨС» 2005 оны хавраас Европын хөлбөмбөгийн томоохон гүрнүүд болох Итали, Англи, Испани, Германы дотоодын аварга шалгаруулах тэмцээний явцыг манай өдөр тутмын хэвлэлүүдээс анх удаа мэдээлж эхэлсэн нь сайшаалтай. Тэмцээний явцыг илэрхийлдэг хэвшмэл хүснэгтийг «ӨС» өөрчилж, хожил, ялагдал, тэнцэл гэсэн дарааллаар мэдээлж байсан нь шаардлагагүй «шинэчлэл» байсан юм. Аливаа тэмцээний явцыг мэдээлэхдээ дэлхий нийтээрээ ялалт, хайнцал, хожигдол гэсэн дарааллыг баримталдаг. Харамсалтай нь «ӨС» ердөө хоёр хүрэхгүй сарын дараа Европын хөлбөмбөгийн томоохон гүрнүүдийн АШТ-ий явцыг мэдээлэхээ зогсоосон билээ.

Манай ХМХ-үүдэд спортын мэргэшсэн сэтгүүлчид дутмаг байгаа, тэд мэдээлж буй зүйлийнхээ талаар заримдаа өөрсдөө ч ямар ч ойлголт, мэдлэггүй байдаг нь сэтгүүл зүйн энэ чиглэлийг түлхүү хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Ишлэл

1. ТВ-9, 2005.04.17.
2. МУТВ, 2005.10.17.
3. МУТВ, «Топ спорт», 2005.05.08.
4. «Өнөөдөр», 2005.06.10.
5. МУТВ, «Топ спорт», 2005.05.01.
6. «Өдрийн сонин», 2005.04.26.
7. Тухайлбал: «Одод олноороо буйр сэлгэв», «Өнөөдөр», 2005.07.23.
8. UBS, 2005.07.27.
9. «Өдрийн сонин», 2005.06.28.
10. «Өнөөдөр», 2005.07.02.
11. «Өнөөдөр», 2005.04.29.
12. МУТВ, «Спорт», 2005.07.24.
13. UBS, 2005.07.27.
14. «Өнөөдөр», 2005.07.02.

15. «Зууны мэдээ», 2005.06.21.
16. «Өнөөдөр», 2005.07.23.
17. «Монголын мэдээ», 2005.08.16.

Резюме

В предлагаемой статье автор рассматривает некоторые аспекты одной из форм журналистики – спортивной. Учитывая, что в нашей стране подготовка и переподготовка спортивных журналистов оставляет желать лучшего, автор уделяет основное внимание недостаткам и всякого рода погрешностям, «ляпам» журналистов, работающих на телевидении и прессе.